46

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 14 өдөр Дугаар 43 Улаанбаатар хот

Сүрьеэгийн тархалтын судалгаа зохион байгуулах тухай

Засгийн газрын 2011 оны 108 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 272 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 71 дүгээр тушаалын биелэлтийг хангах зорилгоор **ТУШААХ НЬ**:

1. Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, 2013-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, судалгаанд хамрагдах аймаг, дүүрэг, сум хорооны жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж, үр дүнг Эрүүл мэндийн сайдын зөвлөл, Сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Глобаль санд хүлээлгэн өгөхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат)-т даалгасугай.

3. Сүрьеэгийн тархалтын судалгааг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, талбарт мэдээлэл цуглуулах, мэдээллийг боловсруулах, тайлагнах, үр дүнг танилцуулах, түгээх, нотолгоонд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд үүрэг болгосугай.

5. Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулахад 2013 онд шаардагдах зардлыг Эрүүл мэндийг дэмжих сангаас, 2014-2015 онд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар (Ц. Цолмонгэрэл)-т даалгасугай.

001675

6. Сүрьеэгийн тархалтын судалгааг гүйцэтгэхэд Глобаль сангийн дэмжлэгтэй төслөөс гарах санхүүжилтийг цаг хугацаанд нь шийдвэрлэж ажиллахыг Эрүүл мэндийн Дэд сайд, төслийн удирдагч (Ж.Амарсанаа)-д үүрэг болгосугай.

7. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн болон төрийн бус байгууллагуудыг энэхүү судалгаанд дайчлан оролцуулах, дэмжлэг авч хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 02 сарын 14-ний өдрийн
43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

48

**Сүрьеэгийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах удирдамж**

## Нэг. Ерөнхий зүйл

### 1.1. Зорилго

Монгол улсын насанд хүрсэн (15 ба түүнээс дээш насны) хүн амын дундах сүрьеэ өвчний цар хүрээг тогтоож, сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

### 1.2. Судалгааны зорилтууд

1. Үндэсний хэмжээнд насанд хүрсэн хүн амын дунд нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн тархалтын суурь үзүүлэлтийг тогтоох
2. Эмнэлзүйн шинж тэмдгээр сүрьеэгийн сэжигтэй тохиолдлын тархалтыг үнэлж, эмнэлзүйн шалгуурыг боловсронгуй болгох
3. Цээжний рентген шинжилгээгээр сүрьеэгийн сэжигтэй тохиолдлын тархалтыг үнэлж, рентген шинжилгээний шалгуурыг боловсронгуй болгох
4. Сүрьеэгийн шинж тэмдэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж эрэлхийлэх зан үйлийг үнэлэх
5. Сүрьеэгийн шинж тэмдэгтэй хүмүүс эрүүл мэндийн байгууллагад хандахгүй байгаа шалтгааныг тогтоох
6. Тархалтын судалгааны үр дүнг сүрьеэгийн чиглэлээр хийсэн бусад судалгаа, хөтөлбөрийн дүн мэдээтэй хослуулан сүрьеэ өвчний дарамт (өвчлөл, тархалт, нас баралт)-ын тооцооллыг шинэчлэх зэрэг болно.

### 1.3. Судалгааны хамрах хүрээ, түүврийн хэмжээ

Судалгааг хүн амд суурилсан агшингийн судалгааны загвараар явуулна. Судалгааны түүвэрлэлтийн хүрээг гаргахад 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоон мэдээг ашигласан бөгөөд Монгол Улсын нийгэм эдийн засаг, газарзүй болон амьдарлын хэв маягийн онцлогийг тусгах зорилгоор түүвэрлэлтийг нийслэл/томоохон хотууд/, аймгийн төв, хөдөөгийн сумууд гэсэн 3 түвшинд хийсэн. Ингэхдээ давхрааны ялгааг арилгах түүвэрлэлтийн аргыг хэрэглэсэн бөгөөд нийт хүн амыг оршин суух газраар нь үндсэн 3 давхраанд хуваасан.

Үүнд:

- Нэгдүгээр давхраа: Улаанбаатар хот, Дархан-Уул ба Орхон аймгийн төв (51 кластер)
- Хоёрдугаар давхраа: Дархан-Уул, Орхон аймгаас бусад бүх аймгийн төв (15 кластер)
- Гуравдугаар давхраа: Аймгийн төвөөс бусад сумууд (32 кластер)

Давхраа бүрээс хамруулах кластерийн тоог хүн амын тоонд нь пропорциональ байхаар тооцсон бөгөөд үндэсний хэмжээнд 49000 хүнийг нийт 98 кластераас сонгон хамруулна.

### Хоёр. Судалгааны бүтэц зохион байгуулалт




### Гурав. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг

3.1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дэргэд Сүрьеэгийн тархалтын судалгааны нэгж байгуулан өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллана.

3.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь Сүрьеэгийн тархалтын судалгааны нэгжийн ажиллах ажлын өрөө, компьютер, принтер, хувилагч, ширээ сандал, холбоо, харилцаа, бичгийн хэрэгсэл, унаа болон дэд бүтцийг бүрэн хариуцан ажиллана.

3.3. Тус төв нь сүрьеэгийн тархалтын судалгааг явуулахад шаардагдах лабораторийн оношлуур, урвалж бодис, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ авна.

3.4. Судалгааны төвийн багийг аймаг, орон нутгийн талбарт ажиллах нөхцөл боломжоор хангахын зэрэгцээ, үндсэн үүрэгт ажил цалгардах, эзэнгүйдэх, мэргэжлийн алдаа, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хүний нөөцийн хувиарлалтыг зохицуулна.

3.5. Сүрьеэгийн тархалтын судалгааны нэгж (цаашид судалгааны нэгж гэнэ) нь зохицуулагч, туслах мэргэжилтэн, мэдээллийн оператор гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

3.6. Судалгааны нэгж нь холбогдох мэргэжилтэнүүд болон мэргэжлийн албатай хамтран арга аргачлал, протоколийг боловсруулж, ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтэнүүдийн саналыг тусган сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөл болон Техникийн ажлын хэсгээр хэлэлцүүлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар судалгааг явуулна.

3.7. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Био-Анагаахын Ёс Зүйн Хяналтын Хороогоор хэлэлцүүлэн судалгааг явуулах ёс зүйн зөвшөөрлийг авсан байна. Мөн судалгааг явуулж дууссаны дараа ёс зүйн дүгнэлт гаргуулсан байна.

3.8. Судалгааны нэгж нь холбогдох мэргэжилтэнүүд, мэргэжлийн албатай хамтран талбарт ажиллах заавар, стандарт үйл ажиллагааны удирдамж боловсруулан Техникийн ажлын хэсгээр хэлэлцэж, ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтэнүүдээс санал авсан байна.

3.9. Судалгааны нэгж нь сургалтын гарын авлага боловсруулан, судлаачдыг сургах, ур чадвар эзэмшүүлэх, дадлагажуулах ажлыг мэргэжлийн алба, мэргэжилтэнүүдтэй хамтран зохион байгуулна.

3.10. ДЭМБ болон олон улсын зөвлөх мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллах, тэднээс ирүүлсэн тайлан, зөвлөмжийг хянах, үнэлэх, хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

3.11. Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, зөвлөхтэй байнга хамтарч тэдний санал, зөвлөмжийг авч ажиллана.

3.12. Судалгааны нэгж дахь орон нутгийн холбогдох албан тушаалтантай холбоо тогтоох (судалгаа эхлэхээс өмнө, судалгааны явцад), бэлтгэл хангуулах арга хэмжээ авна.

3.13. Судалгааг явуулах төлөвлөгөө боловсруулан Эрүүл мэндийн яамаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

3.14. Урьдчилсан судалгаа явуулж судалгааны протокол, үйл ажиллагааны стандарт удирдамж, хэрэглэгдэх тоног төхөөрөмж, мэдээлэл цуглуулах

хэрэгсэлийн тохиромжтой байдлыг үнэлж, сайжруулах арга хэмжээ авахын зэрэгцээ талбарт мэдээлэл цуглуулах боломжтой цаг хугацааны төлөвлөлт хийсний дараа үндсэн судалгааг эхлүүлэх ажлыг хариуцна.

3.15. Мэргэжлийн алба, эмч, мэргэжилтэнүүдтэй хамтран судалгааны талбарт мэдээлэл цуглуулах ажлын явцын байдалд хяналт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг, удирдлагаар хангаж ажиллана.

3.16. Судалгааны баг (төвийн болон талбарын баг)-аас ирүүлсэн мэдээ тайланг хянах, үнэлэх, нэгтгэх ажлыг өдөр тутам хариуцан ажиллана.

3.17. Судалгааны бэлтгэл үе болон судалгааны явцад эсвэл мэдээллийн менежментийн үед гарсан аливаа тулгамдсан асуудлыг хугацаа алдахгүй мэдээлэх, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

3.18. Судалгааны мэдээллийг оруулах, цэгцлэх, хадгалах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих, үр дүнг танилцуулах, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

3.19. Халдварт өвчний дэгдэлт, олныг хамарсан гамшиг, байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол зэрэг онцгой байдал үүссэн үед судалгааны талбарт мэдээлэл цуглуулах ажлыг түр хойшлуулах талаар Техникийн ажлын хэсэг, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

## Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг

4.1. Судалгааны талбарын үндсэн багт эрдэм шинжилгээний ажилтан судлаачдыг оруулж ажиллуулна.

4.2. Урьдчилсан судалгааг зохион байгуулахад үндсэн багт ажиллах эрдэм шинжилгээний ажилтан судлаачдыг бүрэн хамруулна.

4.3. Судалгаанд сонгогдсон аймаг, дүүргийн талбарын ажил эхлүүлэх бэлтгэл хангах хяналт үнэлгээний багт орж ажиллана.

4.4. Сүрьеэгийн тархалтын судалгааны талаар иргэдэд зориулсан мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хийнэ.

## Тав. Аймаг, нийслэлийн Эрүүл газрын гүйцэтгэх үүрэг

5.1. Сүрьеэгийн тархалтын судалгааг харъяа орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан ажиллахын зэрэгцээ дараах бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгийг орон нутгийн засаг захиргаатай зөвшилцөн Засаг даргын захирамж гаргаж хэрэгжүүлнэ. Үүнд: Аймаг, нийслэл, дүүргийн засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн бодлогын хөгжлийн хэлтсийн дарга, статистикийн хэлтсийн дарга, эрүүл мэндийн газрын дарга, цагдаагийн газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга, сум, хороо, багийн засаг дарга, сум, хорооны нийгмийн хөгжлийн бодлогын мэргэжилтэн, хороо, багийн бүртгэл мэдээллийн ажилтан, сум, хорооны хэсгийн ахлагч, аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч, аймгийн эрүүл мэндийн газрын тархвар судлаач,

дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн тархвар судлаач гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.2. Судалгааны талбарт ажиллах талбарын багийн гишүүдэд бүх талын дэмжлэг үзүүлнэ. Үүнд: шаардлагатай унаа, орон байр, хоол хүнс, гэрэл цахилгаан, дулаан, харилцаа холбоо, интернет, хүний нөөцийн зохицуулалт, талбарын багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хариуцан ажиллана.

5.3. Судалгаанд хамрагдах орон нутгийн засаг захиргаа, эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтны утас, факс, email хаяг, газрын зураг, зам харилцааны зураглал гаргасан байна.

5.4. Тухайн орон нутагт судалгаа явуулах хамгийн тохиромжтой цаг хугацааг төлөвлөнө. (улирал, цаг агаар, хөдөлгөөнт хүн ам, хилийн түр болон байнгын боомтын үйл ажиллагаа, мал төллөх, газар тариалангийн ажил, цэрэг татлага зэргийг харгалзан үзнэ)

5.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сүрьеэгийн тархалтын судалгааны талаар хүн ам иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хариуцан зохион байгуулна.

5.6. Судалгааны баг байрлах байр, бүртгэл, ярилцлага хийх, цээжний рентген аппарат, сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангана.

5.7. Орон нутгийн хэмжээнд судалгаанд сонгогдсон хүн амыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

5.8. Судалгааны протокол, үйл ажиллагааны стандарт удирдамжийг баримтлан ажиллана.

## Зургаа. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэх үүрэг

6.1. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрээс сонгогдсон хороо, сум, багуудад амьдарч байгаа 15 ба түүнээс дээш насны судалгаанд оролцох боломжтой хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хүн амын бүртгэл тооллогын судалгааг үндэслэн орон нутгийн ажлын хэсгийн багтай хамтран гаргана.

6.2. Судалгаанд хамрагдах айл өрхийн газрын зураг, зам харилцааны зураглал гаргасан байна.

6.3. Судалгаанд хамрагдах айл бүрээр орж хүн амын тооллого хийх, тэднийг идэвхжүүлэх, урилга хүргэх, судалгаанд хүрэлцэн ирэх цаг хугацааг тохирох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

6.4. Судалгааны багийн байрлах байр, усан хангамж, цахилгааны эх үүсвэр, зочид буудал, хоол хүнс, унаа машин, холбоо харилцааны хэрэгсэл зэрэг дэд бүтцийн асуудлын бэлтгэл хангасан байна.

6.5. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн хүн ам иргэдэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сүрьеэгийн тархалтын судалгааны талаар мэдээлэл, сурталчилгааг хариуцан зохион байгуулна.

6.6. Талбарт мэдээлэл цуглуулах ажлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.7. Судалгаанд хамрагдах хүн амын оролцооны түвшинг сайжруулах арга хэмжээг урьдчилан төлөвлөж хэрэгжүүлнэ.

6.8. Судалгааг явуулах батлагдсан удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд талбарт мэдээлэл цуглуулах ажлыг бүрэн дуусгана.

**Долоо. Төрийн бус байгууллагын гүйцэтгэх үүрэг**

7.1. Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг, Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн нийгэмлэг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудыг энэхүү судалгаанд татан оролцуулна.

7.2. Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэгийн эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнүүдийг судалгааны талбарт мэдээлэл цуглуулах, хүн амд сурталчилгаа хийх, иргэдийг идэвхжүүлэх зэрэг ажилд дайчлан оролцуулна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 02 сарын 14-ний өдрийн 43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## Сүрьеэгийн тархалтын судалгаа зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2015 он )

| Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | | 2013 | | | | 2014 | | | | 2015 | | Хариуцах байгууллага | Хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ул 1 | ул 2 | ул 3 | ул 4 | ул 1 | ул 2 | ул 3 | ул 4 | ул 1 | ул 2 | | |
| Нэг. Сүрьеэгийн тархалтын судалгааны бэлтгэл ажил хангах талаар | | | | | | | | | | | | | |
| 1.1 | ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөлөөр тулгамдсан асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах | | | | | | | | | | | ЭМЯ-ны БХЗГ, Сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөл | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 1.2 | Сүрьеэгийн тархалтын судалгаанд хамрагдах аймаг, нийслэлд Засаг даргын захирамжаар орон нутгийн ажлын хэсэг байгуулан бэлтгэл хангах, үйл ажиллагааг тогтмолжуулах | | | | | | | | | | | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар | ХӨСҮТ, Судалгааны нэгж , ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.3 | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсгээр шаардлагатай асуудлыг хэлэлцэх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах | | | | | | | | | | | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 1.4 | Судалгаанд шаардлагатай лабораторийн урвалж бодис, тоног төхөөрөмжийн захиалга хийх, хүлээн авах, хувиарлах, зарцуулалтанд хяналт тавьж ажиллах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ДЭМБ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.5 | Судалгаанд шаардлагатай рентген аппаратын захиалга хийх, хүлээн авах, ашиглалтанд хяналт тавьж ажиллах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ДЭМБ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.6 | Судалгаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн захиалга, хангалт, хүлээн авах, хувиарлах /явуулын рентген машин, компьютер, бичиг хэргийн зардал болон бусад/ | | | | | | | | | | | ХӨСҮТ, Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ДЭМБ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Сүрьезгийн тархалтын судалгааны протоколийг ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх, гишүүдээс гарсан саналыг тусгаж сайжруулах | | | | | | | | | | | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 1.8 | ХӨСҮТ-ийн Эрдэмтдийн зөвлөлийн хурлаар судалгааны арга аргачлалыг хэлэлцүүлэх, эрдэмтдийн саналыг тусгах, сайжруулах, батлуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.9 | ЭМЯ-ны Био Анагаахын Ёс Зүйн Хяналтын хорооны хурлаар судалгааны арга аргачлалыг хэлэлцүүлж, судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрөл гаргуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.10 | Судалгааны протоколийг ДЭМБ-ын Сүрьезгийн тархалтын судалгааны ажлын хэсэгт илгээх, санал авах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ДЭМБ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.11 | Сүрьезгийн тархалтын судалгааны протоколийг монгол, англи хэлээр хэвлүүлэх, ажлын хэсгийн гишүүдэд түгээх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьезгийн төсөл | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 1.12 | Судалгааны үйл ажиллагааны стандарт удирдамжийг боловсруулах, хэвлүүлэх, нэгжүүдэд хувиарлах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьезгийн төсөл | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.13 | Сүрьезгийн тархалтын судалгаа явуулах сургалтын гарын авлага боловсруулах, хянуулах, хэвлүүлэх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьезгийн төсөл | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 1.14 | Сүрьезгийн тархалтын судалгааг явуулах судлаачдын сургалтын тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх /багийн ахлагч, төвийн баг, талбарын баг, лаборатори, рентген, зохион байгуулалт, мэдээлэл цуглуулах, бүртгэл, тооллого, дата менежмент бусад/ | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүрьезгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьезгийн төсөл, ДЭМБ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.15 | Сүрьеэгийн тархалтын судалгааны талаар хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны материал боловсруулах, хянах, хэвлүүлэх, түгээх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, ДЭМБ |
| **Хоёр. Сүрьеэгийн тархалтын судалгааны талбарын үйл ажиллагааны талаар** | | | | | | | | | | | | | |
| **2.1 Судалгааны бэлтгэл ажил хангах талаар Улаанбаатар хотод эхний болон хоёрдах удаагийн үнэлгээ хийх** | | | | | | | | | | | | | |
| 2.1.1.1 | Баянзүрх дүүргийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, БЗД-ийн НЭМТ |
| 2.1.1.2 | Баянгол дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, БГД-ийн НЭМТ |
| 2.1.1.3 | Налайх дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, Налайх дүүргийн НЭМТ |
| 2.1.1.4 | Хан-уул дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Хан-уул дүүргийн НЭМТ |
| 2.1.1.5 | Сүхбаатар дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, Сүхбаатар дүүргийн НЭМТ |
| 2.1.1.6 | Чингэлтэй дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Чингэлтэй дүүргийн НЭМТ |
| 2.1.1.7 | Сонгинохайрхан дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Сонгинохайрхан дүүргийн НЭМТ |
| 2.1.1.8 | Багануур дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, НЭМГ, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Багануур дүүргийн НЭМТ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1.9 | Дархан-Уул аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах, хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Дархан-уул аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.1.1.10 | Орхон аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах, хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, Орхон аймгийн эрүүл мэндийн газар |
| **2.2 Судалгааны бэлтгэл ажил хангах талаар аймгуудад эхний болон хоёрдах удаагийн үнэлгээ хийх** | | | | | | | | | | | | | |
| 2.2.1 | Архангай аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Архангай аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.2 | Баян-Өлгий аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Баян-өлгий аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.3 | Баянхонгор аймгийнсудалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.4 | Булган аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Булган аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.5 | Говь-Алтай аймагт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Говь-алтай аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.6 | Дорноговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Дорноговь аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.7 | Дорнод аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Дорнод аймгийн эрүүл мэндийн газар |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.8 | Дундговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Дундговь аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.9 | Завхан аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Завхан аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.10 | Өвөрхангай аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.11 | Өмнөговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.12 | Сүхбаатар аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.13 | Сэлэнгэ аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.14 | Төв аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Төв аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.15 | Увс аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар,БХЗГ, Увс аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.16 | Ховд аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Ховд аймгийн эрүүл мэндийн газар |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.17 | Хөвсгөл аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газар |
| 2.2.18 | Хэнтий аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Хэнтий аймгийн эрүүл мэндийн газар |
| | **2.3 Урьдчилсан судалгаа** | | | | | | | | | | | | |
| 2.3.1 | Сүрьеэгийн тархалтын судалгааны урьдчилсан судалгааг Хан-уул дүүрэгт хийж, арга аргачлал, мэдээлэл цуглуулах хэрэгсэл болон судалгааны протоколийг сайжруулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.3.2 | Сүрьеэгийн тархалтын судалгааны урьдчилсан судалгааг Төв аймагт хийж, арга аргачлал, мэдээлэл цуглуулах хэрэгсэл болон судалгааны протоколийг сайжруулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Төв аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| | **2.4.1 Улаанбаатар хотын судалгааны нэгжид ажиллах (талбарт мэдээлэл цуглуулах)** | | | | | | | | | | | | |
| 2.4.1.1 | Баянзүрх дүүргийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.2 | Баянгол дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар,ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.3 | Налайх дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдийн бэлтгэл ажлыг хангуулах хяналт үнэлгээ хийх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.1.4 | Хан-уул дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.5 | Сүхбаатар дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.6 | Чингэлтэй дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.7 | Сонгинохайрхан дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.8 | Багануур дүүрэгт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.9 | Дархан-Уул аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.1.10 | Орхон аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийннэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Орхон аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| | **2.4.2 Улаанбаатар хотын судалгааны нэгжид ажиллах (талбарт мэдээлэл цуглуулах)** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.2.1 | Архангай аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Архангай аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг , Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.2 | Баян-Өлгий аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Баян-өлгий аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг , Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.3 | Баянхонгор аймгийнсудалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.4 | Булган аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Булган аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.5 | Говь-Алтай аймагт судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Говьалтай аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.6 | Дорноговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Дорноговь аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг , Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.7 | Дорнод аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Дорнод аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.2.8 | Дундговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Дундговь аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.9 | Завхан аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдийн нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Завхан аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг , Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.10 | Өвөрхангай аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.11 | Өмнөговь аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.12 | Сүхбаатар аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.13 | Сэлэнгэ аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.14 | Төв аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Төв аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.2.15 | Увс аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Увс аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.16 | Ховд аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Ховд аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.17 | Хөвсгөл аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 2.4.2.18 | Хэнтий аймгийн судалгаанд сонгогдсон нэгжүүдэд мэдээлэл цуглуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Хэнтий аймгийн эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| **2.5 Сүрьеэгийн тархалтын судалгааны бэлтгэл болон явцад хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ** | | | | | | | | | | | | | |
| 2.5.1 | Улаанбаатар хотын сонгогдсон 10 нэгжийн бэлтгэл ажлын хангалт болон талбарын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх | | | | | | | | | | | ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн тархалтын судалгааны удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 2.5.2 | Аймгийн судалгаанд сонгогдсон 10 нэгжийн бэлтгэл ажлын хангалт болон талбарын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх | | | | | | | | | | | ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн тархалтын судалгааны удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл | ХӨСҮТ, Судалгааны нэгж, аймгийн эрүүл мэндийн газар |
| **Гурав . Сүрьеэгийн тархалтын судалгааны мэдээллийн менежментийн талаар** | | | | | | | | | | | | | |
| 3.1 | Судалгааны мэдээллийг оруулах, нэгдсэн сан үүсгэх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | Судалгааны мэдээллийг хадгалах, сэргээх, найдвартай байдлыг хангах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 3.3 | Судалгааны мэдээллийг цэгцлэх, боловсруулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 3.4 | Судалгааны мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийхэд ДЭМБ-ын зөвлөх мэргэжилтэн урьж ажиллуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг | ДЭМБ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 3.5 | Судалгааны нэгдсэн тайлан бичих | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 3.6 | Судалгааны нэгдсэн тайланг хянуулах | | | | | | | | | | | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 3.7 | Судалгааны нэгдсэн тайлан орчуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 3.8 | Судалгааны нэгдсэн тайланг хэвлүүлэх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 3.9 | Судалгааны тайланг байршуулах, түгээх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 3.10 | Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 3.11 | Олон улсын сэтгүүлд судалгааны үр дүнг нийтлүүлэх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 3.12 | Судалгааны мэдээллийг нэгдсэн сан үүсгэж архивлах, хадгалах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| **Дөрөв. Сүрьеэгийн тархалтын судалгааны хүний нөөцийн менежментийн талаар** | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Үндсэн судлаач (хагас цагаар) сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг |
| 4.2 | Судалгааны үндсний зөвлөх (хагас цагаар) сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн тархалтын судалгааны Удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг |
| 4.3 | Талбарын багийн ахлагчийг томилох, ажил үүргийн хуваарийг гаргаж батлуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 4.4 | Талбарын багийн гишүүдийг томилох, ажил үүргийн хуваарийг гаргаж батлуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 4.5 | Мэдээллийн менежментийн нэгж байгуулж ажиллуулах, ажил үүргийн хуваарийг гаргах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, Үндсэн судлаач, үндэсний зөвлөх | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг |
| 4.6 | Мэдээллийн менежментийн нэгжид ажиллах дата операторуудыг сонгож авах, гэрээ байгуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 4.7 | Сүрьеэгийн тархалтын судалгааны талбарт мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ДЭМБ-ийн зөвлөх мэргэжилтэн урьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж | ДЭМБ, Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 4.8 | Дүрс оношлогооны эмч (рентген зөвлөх) сонгож гэрээ байгуулж ажиллуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж,ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Сүрьеэгийн тархалтын судалгааны үндсэн судлаач, үндэсний зөвлөх |
| 4.9 | Судалгааны явцад сүрьеэгийн лабораторит нэмэлтээр ажиллах хүний нөөцийг судлаж авах, сургах, дадлагажуулах, гэрээ байгуулах | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |
| 4.10 | Судалгаанд оролцогчдод өгөх урамшууллыг тооцох, олгох | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, БХЗГ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.11 | Судалгаанд шаардлагатай санхүүжилтийг цаг тухайд тооцож төлөвлөх, тайлан мэдээг сар бүр гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх | | | | | | | | | | | ХӨСҮТ, Судалгааны нэгж, ЭМЯ-ны дэргэдэх Техникийн ажлын хэсэг, | ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл |

67

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
02 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

**Сүрьеэгийн тархалтын судалгаанд хамрагдах аймаг, сум, баг, дүүрэг, хорооны жагсаалт**

Судалгаанд сонгогдсон аймгийн төвийн сум, багууд

| № | Сонгогдсон аймгийн нэр | Аймгийн төвийн сумын нэр | Багийн нэр |
|---|---|---|---|
| 1 | Хөвсгөл аймаг | Мөрөн сум | 1-р баг |
| 2 | Дорноговь аймаг | Сайншанд сум | 4-р баг |
| 3 | Ховд аймаг | Жаргаланд сум | 8-р баг |
| 4 | Говь-Алтай аймаг | Есөнбулаг сум | 3-р баг |
| 5 | Баян-Өлгий аймаг | Өлгий сум | 4-р баг |
| 6 | Дорнод аймаг | Хэрлэн сум | 6-р, 10-р баг |
| 7 | Баянхонгор аймаг | Баянхонгор сум | 4-р, 6-р баг |
| 8 | Булган аймаг | Булган сум | 1-р баг |
| 9 | Төв аймаг | Зуунмод сум | 3-р баг |
| 10 | Увс аймаг | Улаангом сум | 7-р баг |
| 11 | Архангай аймаг | Эрдэнэбулган сум | 1-р баг |
| 12 | Өмнөговь аймаг | Даланзадгад сум | 4-р баг |
| 13 | Хэнтий аймаг | Хэрлэн сум | 5-р баг |

Судалгаанд сонгогдсон хотын дүүрэг, хороо, багийн жагсаалт

| № | Дүүргийн нэр | Хорооны дугаар |
|---|---|---|
| 1 | Багануур | 4-р хороо |
| 2 | Баянгол | 3-р хороо |
| 3 | | 6-р хороо |
| 4 | | 8-р хороо |
| 5 | | 11-р хороо |
| 6 | | 12-р хороо |
| 7 | | 13-р хороо |
| 8 | | 18-р хороо |
| 9 | Баянзүрх | 2-р хороо |
| 10 | | 4-р хороо |
| 11 | | 6-р хороо |
| 12 | | 8-р хороо |
| 13 | | 12-р хороо |
| 14 | | 13-р хороо |
| 15 | | 14-р хороо |
| 16 | | 16-р хороо |
| 17 | | 18-р хороо |
| 18 | | 21-р хороо |
| 19 | | 23-р хороо |
| 20 | Налайх | 1-р хороо |
| 21 | Сонгинохайрхан | 3-р хороо |
| 22 | | 4-р хороо |
| 23 | | 5-р хороо |
| 24 | | 6-р хороо |
| 25 | | 7-р хороо |
| 26 | | 9-р хороо |
| 27 | | 14-р хороо |
| 28 | | 19-р хороо |
| 29 | | 25-р хороо |
| 30 | Сүхбаатар | 7-р хороо |
| 31 | | 10-р хороо |
| 32 | | 15-р хороо |
| 33 | | 16-р хороо |
| 34 | | 18-р хороо |
| 35 | Хан-Уул | 1-р хороо |
| 36 | | 3-р хороо |
| 37 | | 8-р хороо |
| 38 | | 11-р хороо |
| 39 | | 12-р хороо |
| 40 | Чингэлтэй | 7-р хороо |
| 41 | | 8-р хороо |
| 42 | | 10-р хороо |
| 43 | | 13-р хороо |
| 44 | | 15-р хороо |
| 45 | | 18-р хороо |

| Аймаг, сум | | Баг |
|---|---|---|
| 46 | Дархан-Уул аймаг - | 2-р баг |
| 47 | Дархан сум | 4-р баг |
| 48 | | 10-р баг |
| 49 | Орхон аймаг - | 3-р баг |
| 50 | Баян-Өндөр сум | 6-р баг |
| 51 | | 7-р баг |

Судалгаанд сонгогдсон аймаг, сумууд

| № | Аймгийн нэр | Сумын нэр |
|---|---|---|
| 1 | Архангай | Өндөр-Улаан |
| 2 | | Хангай |
| 3 | Баян-Өлгий | Булган |
| 4 | Баянхонгор | Шинэжинэст |
| 5 | Булган | Баяннуур |
| 6 | Говь-Алтай | Бугат |
| 7 | | Цээл |
| 8 | Дорноговь | Замын-Үүд |
| 9 | Дорнод | Хөлөнбуйр |
| 10 | | Цагаан-Овоо |
| 11 | Дундговь | Баянжаргалан |
| 12 | Завхан | Сантмаргац |
| 13 | | Тосонцэнгэл |
| 14 | Өвөрхангай | Богд |
| 15 | | Сант |
| 16 | | Хархорин |
| 17 | Өмнөговь | Номгон |
| 18 | | Ханхонгор |
| 19 | Сүхбаатар | Мөнххаан |
| 20 | Сэлэнгэ | Ерөө |
| 21 | | Мандал |
| 22 | | Сант |
| 23 | Төв | Батсүмбэр |
| 24 | | Борнуур |
| 25 | | Жаргалант |
| 26 | Увс | Өлзий |
| 27 | | Хяргас |
| 28 | Ховд | Булган |
| 29 | Хөвсгөл | Алаг-Эрдэнэ |
| 30 | | Улаан-Уул |
| 31 | | Цагааннуур |
| 32 | Хэнтий | Норовлин |